

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ДУГААР 151011-7
ХАВСРАЛТ 0
ОГНОО 2021 оны 12-р сарын 28-ны өдөр

УТГА Компанийг хувьцаат компани болгох замаар хэлбэрийг өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК (“Компани”)–ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн ээлжит бус хурал (“Хурал”)–ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийг хувьцаат компани болгох замаар Компанийн хэлбэрийг өөрчилж, Компанийн оноосон нэрийн ард Компанийн хэлбэрийг тодорхойлсон хувьцаат компани буюу “ХК” гэсэн ялгах тэмдэглэгээтэй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Компанийг хувьцаат компани болгох замаар хэлбэрийг өөрчилсөн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

А.ГАНХУЯГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ДУГААР	151011-8
ХАВСРАЛТ	0
ОГНОО	2021 оны 12-р сарын 28-ны өдөр
УТГА	Компанийн оршин байгаа хаягийг өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дах заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК (“Компани”)–ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн ээлжит бус хурал (“Хурал”)–ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 14220, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж 31, Далай Тауэр, 11-н давхарт хэмээн өөрчилж Компанийн Дүрэмд тусгахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн оршин байгаа хаягийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

А.ГАНХУЯГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ДУГААР	151011-9
ХАВСРАЛТ	
ОГНОО	2021 оны 12-р сарын 28-ны өдөр
УТГА	Компанийн Дүрмийн төслийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн ээлжит бус хурал (“Хурал”)-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Дүрмийг хавсралт ёсоор баталсугай.
2. Компанийн Дүрмийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

А.ГАНХУЯГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ДУГААР	151011-10
ХАВСРАЛТ	
ОГНОО	2021 оны 12-р сарын 28-ны өдөр
УТГА	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн ээлжит бус хурал (“Хурал”)-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн ердийн гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Адилбиш овогтой Ганхуяг,
 - (ii) Адилбиш овогтой Ганболд,
 - (iii) Гансүх овогтой Бат-Эрдэнэ,
 - (iv) Очирбат овогтой Батмөнх,
 - (v) Болдбаатар овогтой Бат-Эрдэнэ,
 - (vi) Ганболд овогтой Чинзориг.
2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Равжин овогтой Ганболд,
 - (ii) Чулуун овогтой Мэргэн,
 - (iii) Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo).
3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

А.ГАНХУЯГ